

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/41/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.govisumber@audit.gov.mn Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: batsaikhants@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3 12	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,561,484.97	176,062,761.95
33	АВЛАГА	245,629.32	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	245,629.32	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	154,315,855.65	176,062,761.95
35100	Түүхий эд материал	469,230.00	631,430.00
35130	Эм боох материал	469,230.00	631,430.00
35400	Хангамжийн материал	153,846,625.65	175,431,331.95
35410	Бичиг хэргийн материал	1,344,000.00	1,412,200.00
35420	Аж ахуйн материал	97,971,491.60	110,545,096.44
35440	Түлш, шатах тослох материал	160,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	330,000.00	0.00
35460	Хүнсний материал	0.00	678,713.50
35470	Бусад хангамжийн материал	54,041,134.05	62,795,322.01

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,709,801,542.31	1,688,322,992.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,709,801,542.31	1,688,322,992.42
39200	Биет хөрөнгө	1,504,664,042.31	1,482,615,492.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,424,685,337.86	1,424,685,337.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,728,064.62	-127,622,443.62
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	185,278,104.00	173,881,836.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-114,745,671.25	-56,704,503.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,539,201.21	117,509,993.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-59,401,359.99	-62,257,351.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,307,287.40	31,343,302.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,270,792.30	-18,220,679.95
39300	Биет бус хөрөнгө	205,137,500.00	205,707,500.00
39301	Програм хангамж	1,361,600.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,259,100.00	-77,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	205,035,000.00	205,035,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,864,363,027.28	1,864,385,754.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	245,629.32	1,031,118.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	245,629.32	1,031,118.00
41300	Өглөг	245,629.32	1,031,118.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	245,629.32	281,075.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	8,000.00
41360	Бусад өглөг	0.00	742,043.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	742,043.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,864,117,397.96	1,863,354,636.37
51	Засгийн газрын хувь оролцоо	1,864,117,397.96	1,863,354,636.37
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	631,596,249.02	631,596,249.02
51200	Хуримтлагдсан үр дүн	462,865,796.07	462,103,034.48
51210	Өмнөх үеийн үр дүн	272,889,144.39	462,865,796.07
51220	Тайлант үеийн үр дүн	189,976,651.68	-762,761.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	769,655,352.87	769,655,352.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,864,363,027.28	1,864,385,754.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,683,425,159.11	1,538,558,157.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	297,766,009.11	103,304,757.36
120	Нийтлэг татварын бус орлого	297,766,009.11	103,304,757.36
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	279,834,936.00	84,628,446.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	17,931,073.11	18,676,311.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,385,659,150.00	1,435,253,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,275,283,900.00	1,322,779,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,275,283,900.00	1,322,779,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,069,250.00	10,770,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,706,050.00	10,770,000.00

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	363,200.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,306,000.00	101,704,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,306,000.00	101,704,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,493,448,507.43	1,539,320,918.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,448,507.43	1,539,320,918.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,435,088,630.29	1,497,683,587.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,065,001,798.00	1,120,870,981.00
210101	Үндсэн цалин	755,651,648.00	961,482,018.00
210102	Нэмэгдэл	168,095,826.00	116,378,218.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,712,925.00	2,520,000.00
210104	Урамшуулал	129,541,399.00	40,490,745.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,859,687.86	143,974,775.44
210201	Тэтгэврийн даатгал	92,100,471.00	101,451,673.66
210202	Тэтгэмжийн даатгал	10,425,789.00	10,903,535.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,999,716.49	9,197,027.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,852,358.37	2,038,533.59
210205	Эрүүл мэндийн даатгал	18,481,353.00	20,384,006.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,487,942.00	94,777,474.00
210301	Гэрэл, цахилгаан	1,565,469.00	1,933,954.00
210302	Түлш, халаалт	85,846,683.00	91,491,620.00
210303	Цэвэр, бохир ус	7,075,790.00	1,351,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,115,117.42	21,456,388.46
210401	Бичиг хэрэг	9,678,330.00	3,020,177.00
210402	Тээвэр, шатахуун	840,000.00	676,806.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	257,857.00	332,837.00
210404	Ном, хэвлэл	11,923,106.00	2,847,684.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,235,824.42	14,398,884.46
2105	Нормативт зардал	821,585.00	155,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	821,585.00	155,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	698,420.00	330,000.00
210604	Урсгал засвар	698,420.00	330,000.00
2107	Томилолт, зочны зардал	402,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	402,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,358,300.00	3,003,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,300.00	503,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,728,000.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,343,780.01	113,115,268.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,209,526.00	774,273.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,134,254.01	112,340,995.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,359,877.14	41,637,331.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,973,100.00	37,741,178.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,109,900.00	32,700,778.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,863,200.00	5,040,400.00

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	397,558.00	3,689,326.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	397,558.00	3,689,326.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,989,219.14	206,826.26
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,989,219.14	206,826.26
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	189,976,651.68	-762,761.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	189,976,651.68	-762,761.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	631,596,249.02	769,655,352.87	462,865,796.07	1,864,117,397.96
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	631,596,249.02	769,655,352.87	462,865,796.07	1,864,117,397.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	631,596,249.02	769,655,352.87	462,865,796.07	1,864,117,397.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-762,761.59	-762,761.59
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	631,596,249.02	769,655,352.87	462,103,034.48	1,863,354,636.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,385,659,150.00	1,440,231,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,385,659,150.00	1,440,231,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,275,283,900.00	1,322,779,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,275,283,900.00	1,322,779,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,069,250.00	15,747,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,770,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,069,250.00	4,977,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,306,000.00	101,704,000.00

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,306,000.00	101,704,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,385,659,150.00	1,433,997,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,659,150.00	1,433,997,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,327,299,272.86	1,391,830,455.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,064,850,000.00	1,124,890,081.44
210101	Үндсэн цалин	678,216,700.00	966,951,281.44
210102	Нэмэгдэл	213,120,800.00	119,134,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	2,520,000.00
210104	Урамшуулал	161,512,500.00	36,284,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,011,485.86	139,674,600.00
210201	Тэтгэврийн даатгал	98,438,424.12	125,312,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,538,787.00	3,590,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,677,291.90	2,872,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,937,743.84	718,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,419,239.00	7,181,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,487,942.00	94,777,474.00
210301	Гэрэл, цахилгаан	1,565,469.00	1,933,954.00
210302	Түлш, халаалт	85,846,683.00	91,491,620.00
210303	Цэвэр, бохир ус	7,075,790.00	1,351,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,738,250.00	18,237,100.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,615,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	358,806.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	332,837.00
210404	Ном, хэвлэл	6,006,050.00	4,977,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,372,200.00	10,772,757.00
2105	Нормативт зардал	2,025,095.00	1,012,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999,895.00	332,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,025,200.00	680,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,420,500.00	6,237,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	9,420,500.00	3,237,200.00
2107	Томилолт, зочны зардал	402,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	402,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,204,300.00	3,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764,300.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,159,700.00	3,702,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,159,700.00	3,702,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,359,877.14	42,166,544.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,973,100.00	38,270,392.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,109,900.00	33,229,992.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,863,200.00	5,040,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	397,558.00	3,689,326.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	397,558.00	3,689,326.00

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,989,219.14	206,826.26
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,989,219.14	206,826.26
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	6,234,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	6,234,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6,234,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	6,234,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	6,234,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-6,234,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,424,483,400.00	1,420,587,247.74	3,896,152.26	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,424,483,400.00	1,420,587,247.74	3,896,152.26	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,386,213,000.00	1,382,316,855.44	3,896,144.56	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,124,896,900.00	1,124,890,081.44	6,818.56	100.0
210101	Үндсэн цалин	967,163,500.00	966,951,281.44	212,218.56	99.9
210102	Нэмэгдэл	119,134,600.00	119,134,600.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,314,600.00	2,520,000.00	-205,400.00	108.8
210104	Урамшуулал	36,284,200.00	36,284,200.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,674,600.00	139,674,600.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	125,312,500.00	125,312,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,590,500.00	3,590,500.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,872,400.00	2,872,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	718,200.00	718,200.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,181,000.00	7,181,000.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,466,800.00	94,777,474.00	3,689,326.00	96.2
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	1,933,954.00	1,066,046.00	64.4
210302	Түлш, халаалт	89,466,800.00	91,491,620.00	2,024,820.00	102.6
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	1,351,900.00	4,648,100.00	22.5
2104	Хангамж, бараа материалын зардал	9,873,500.00	9,873,500.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	777,800.00	1,615,100.00	-837,300.00	207.6
210402	Тээвэр, шатахуун	1,752,500.00	358,806.00	1,393,694.00	20.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	791,200.00	332,837.00	458,363.00	42.0

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	311,000.00	0.00	311,000.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272,100.00	180,000.00	92,100.00	66.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,968,900.00	7,386,757.00	1,417,857.00	123.5
2105	Нормативт зардал	1,012,000.00	1,012,000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	332,000.00	332,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	680,000.00	680,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,737,200.00	6,737,200.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,237,200.00	3,237,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	0.00	200,000.00	0.0
210702	Дотоод албан томилолт	200,000.00	0.00	200,000.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,052,000.00	2,052,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,052,000.00	2,052,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,270,400.00	38,270,392.30	7.70	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,270,400.00	38,270,392.30	7.70	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,230,000.00	33,229,992.30	7.70	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,040,400.00	5,040,400.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,424,483,400.00	1,420,587,247.74	3,896,152.26	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,322,779,400.00	1,322,572,573.74	206,826.26	99.9
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,322,779,400.00	1,322,572,573.74	206,826.26	99.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	101,704,000.00	98,014,674.00	3,689,326.00	96.3
320001	Орон нутгийн төсвөөс	101,704,000.00	98,014,674.00	3,689,326.00	96.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,747,600.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,747,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,747,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,097,600.00
210404	Ном, хэвлэл	4,977,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,650,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,747,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,747,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,770,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,977,600.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ-ын төлбөрийн баримтын цахим систем, бараа материалын зардлын ангилал, өглөгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудит Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 05 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдлыг арилгахад бүх талын оролцоо,хамтын ажиллагааг хөгжүүлж,тэдний хөгжил төлөвшил,сурлагын амжилт,чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурлагын хоцрогдлыг арилгах, сурагчдын суралцах үйл явцын судалгаа гаргаж, багш бүрийн хоцрогдлыг нөхөх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, сурлагын амжилт чанарыг тогтмол үнэлэх
- Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг хөгжүүлж, эцэг эх, сургуулийн холбоог бэхжүүлж, суралцах таатай орчин бүрдүүлэх, хамтран суралцахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах
- Багшийг ажлын байран дээрээ тасралтгүй хөгжүүлэх, чадварлаг багш хөтөлбөрийг үе шаттай хжржжүүлэх
- Хүүхдийн хөгжил төлөвшилд чиглэсэн өөрийн удирдах байгууллага, дугуйланг хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба Засаг даргын баталсан удирдамж, байгууллагын 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шалгалтыг 2019-2020 оны санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой баримтууд, өмнөх онд хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлагын биелэлт, өр авлагын барагдуулалт, үүссэн өр, авлагыг данс бүртгэлд тусгасанн эсэх, хууль, тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэр, заавар журмын биелэлт, илэрсэн зөрчлийг арилгуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хийж гүйцэтгэсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн баталсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардал 1,424,483.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,244.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 9,971.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.7 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	245.6		(245.6)
Бараа материал	154,315.8	176,062.7	21,746.9
Үндсэн хөрөнгө	1,709,801.6	1,688,323.0	(21,478.6)
Нийт хөрөнгө	1,864,363.0	1,864,385.7	22.7
Богино хугацаат өр төлбөр	245.6	1,031.1	785.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,864,117.4	1,863,354.6	(763.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,864,363.0	1,864,385.7	22.7

Авлага дансны эхний үлдэгдэл 245.6 мянган төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 176,062.7 мянган төгрөг болж 21,746.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалт болон үнэ төлбөргүй орсон орлогын бараа материал зарцуулагдагдаагүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,863,354.6 мянган төгрөг болж 763.0 мянган төгрөгөөр буурсан нь авлага, бараа материал дансны үлдэгдлүүд материаллаг хэмжээгээр буурснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 144,867.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлогууд байна. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого 194,461.3 мянган төгрөгөөр өссөн;
- Тусламж, санхүүжилтийн орлого 49,594.3 мянган төгрөгөөр буурсан;

Нийт зардал өмнөх оноос 45.872.4 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,617,273.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 453,403.3 мянган төгрөгөөр бууруулж, төсвийн тодотголыг 8 удаа хийж 1,424,483.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийг 12 дугаар сард 1,424,483.4 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвийн санхүүжилтээс 1,322,779.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 101,704.0 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,424,483.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,322,779.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 101,704.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,322,572.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 98,014.7 мянган төгрөг, нийт 1,420,587.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.7 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 3,896.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 10,770.0 мянган, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,977.6 мянган, нийт 15,747.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: ном, хэвлэл, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, багаж, техник, хэрэгсэл, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 15,747.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхийн нийтээр Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалын дагуу боловсролын салбар байгууллагуудын сургалтын үйл ажиллагааг 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр явуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 2021 онд нийт 1,420,587.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан, мэдээллийг мэдээлж, тухай бүр оруулах 8, сар бүрийн оруулах 3, улирал бүр оруулах 3, нийт 14 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тайлант онд 42,554.7 мянган төгрөгийн мэдээллийг 0 дүнтэй мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтын 8,672.5 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн и-баримт цахим төлбөрийн баримтын системд байршуулсан мэдээлэл нь Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар тогтоосон 3 төлбөрийн акт, 1 албан шаадлага бүрэн хэрэгжиж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил тайлант онд давтагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх

нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын нийт 59,653.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 7,278.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 52,374.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 49,681.6 мянган төгрөг их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

1.1 Илрүүлэлт: Аудитаар тайлант онд акталсан бараа материалын зардлын дансны эдийн засгийн ангиллыг санхүүгийн үр дүнгийн тайланд буруу бүртгэж, тайлагнасан 7,278.9 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

4.2 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 785.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөр үүсгэхгүй ажиллаж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх.

1.2 Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтын 8,672.5 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтын дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим системд тухай бүр шивүүлж, хяналт хэрэгжүүлж байх

1.3 Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 149 мэдээллээс 14 мэдээллийг хоцроож байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тухай бүр үнэн зөв байршуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд актлагдсан бараа материалын зардлын ангиллыг буруу бүртгэж тай-лагнасан	1	7,278.9	1	7,278.9						
2	Тайлант хугацаанд өглөг нэмэгдүүлсэн	1	785.5							1	785.5
3	Тайлант хугацаанд цахим төл-бөрийн системд 9,033.9 мянган төгрөгийн худалдан авалт зөрүүтэй оруулсан. Үүнээс: 361.4 мянган төгрөгийн худалдан авалтыг илүү, 8,672.5 мянган төгрөгийн баримтыг шивэгдээгүй байна.	1	9,033.9							1	9,033.9
4	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулах 8 төрлийн мэдээлэл, сар бүрийн оруулах 3 төрлийн мэдээлэл, улирал бүр оруулах 3 төрлийн мэдээ-лэл, нийт 14 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна	1								1	
5	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 6, 7,8, 9, 11, 12 дугаар саруудын "Цал-ингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ"-д байршуулах 42,554.7 мянган төгрөгийн мэдээллийг 0 дүнтэй мэдээлсэн.	1	42,554.7							1	42,554.7
	НИЙТ ДҮН	5	59,653.0	1	7,278.9					4	52,374.1

Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан